



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2019 оны 10 сарын 10 өдөр

Дугаар 398

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 20 дугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. “Эрдэнэтийн дулааны цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 119,000,000.00 (нэг зуун арван есөн сая) төгрөгийн балансын үнэтэй, 111,849,133.36 (нэг зуун арван нэгэн сая найман зуун дөчин есөн мянга нэг зуун гучин гурван төгрөг гучин зургаан мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг “Хөвсгөл дулааны станц” төрийн өмчит хувьцаат компанид балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга, “Эрдэнэтийн дулааны цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Л.Эрхбаатар, “Хөвсгөлийн дулааны станц” төрийн өмчит хувьцаат компанийн захирал Ч.Цогоо нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.


3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД



0000810

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2019 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн
 398 дугаар тогтоолын хавсралт

"ЭРДЭНЭТИЙН ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИАС "ХӨВСГӨЛ ДУЛААНЫ СТАНЦ" ТӨРИЙН
 ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ЖАГСААЯТ

Д/д	Автомашини марк, улсын дугаар, арал	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Явсан км	Балансын үнэ (төгрөг)	Хурифтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)
1	Суудлын автомашин, Тоёото Ланд Круйзер-200, 09-00 ОРО, JTMДУ09J7B4044574	2011/2011	269,545.00	119,000,000.00	111,849,133.36	7,150,866.64
Нийт дүн						
				(нэг зуун арван есөн сая)	(нэг зуун арван нэгэн сая найман зуун дөчин есөн мянга нэг зуун гучин гурван төгрөг гучин зургаан мөнгө)	(долоон сая нэг зуун тавин мянга найман зуун жаран зургаан төгрөг жаран дөрвөн мөнгө)